

**“ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ НИЙГМИЙН ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР”
(II ҮЕ ШАТ 2009-2017)-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

2009 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл
1	Хөтөлбөрийг баталсан ЗГ-ын тогтоолын дугаар, огноо		Засгийн Газрын 2009 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 173 дугаар тогтоол
2	Хөтөлбөрийн хэрэгжүүлэлтийн үргэлжлэх хугацаа		2009-2017 он
3	Хөтөлбөрийн зорилго		Засгийн газар, хоршоо, хоршоог дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, хоршоо хөгжих эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх замаар хоршооны нийгэмд гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх, өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлэх, ажлын байр, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд оршино.
4	Хөтөлбөрийн зорилтууд	I үе шат (2009-2013)	Хоршооны хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх.
		II үе шат (2013-2017)	Хоршоог санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцох байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, үр дүнг тодорхой тооцдог болох. Хоршооны үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээ, үйлчилгээг бий болгох. Хоршоодын мэдээллийн нэгдсэн санг баяжуулж, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх.
5	Зардал (сая.төг)	Төсөв (тайлант оны)	158.0 сая төгрөг
		Гүйцэтгэл (тайлант оны)	Хөтөлбөр 2009 оны 6 сарын 10-нд батлагдаж, төсвийн тодотголд тусгагдаагүй тул тайлант хугацаанд санхүүжилт байхгүй.
6	Хөтөлбөрийн хэрэгжилт (хүрсэн үр дүн, үр ашиг, үр нөлөө)		Тайлант хугацаанд төсөв батлагдаагүй ч хөтөлбөрөөс дараахь ажлуудыг гүйцэтгэж иржээ. Үүнд: 1.Иргэд хөдөлмөрөө хоршин, хөрөнгө, хүчээ нэгтгэн ажлын байр шинээр бий болгож, өрхийн орлогоо нэмэгдүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээгээ өргөтгөх зэрэг олон асуудлыг төрд дарамт учруулахгүйгээр шийдвэрлэж, эдийн засаг нийгмийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж буй асуудалд ач холбогдол өгч Хоршоо, бичил, бизнесийг дэмжих хэлтсийг Жижиг, дунд үйлдвэрийн газрын бүтцэд оруулж байгуулсан. 2.Хоршоод өнөөдөр зах зээлд өрсөлдөх чадвартай болж, нийгэмд үзүүлж байгаа үр өгөөж дээшилж байгаа нь жил бүр зохиогдож буй “Намрын

	<p>ногоон өдрүүд”, “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн, худалдаа болон аймаг, орон нутаг, бүсийн үзэсгэлэнгүүдийн дүнгээс харагдаж байна. 2009 онд үзэсгэлэнд нийт 30-аад хоршоод 80 гаруй төрлийн нэрийн бүтээгдэхүүнээ танилцуулж, ХХААХҮЯ-наас шалгаруулсан “Шилдэг хүнсний ногоо боловсруулагч аж ахуйн нэгж”, ЖДҮГ-аас шалгаруулсан “Хоршооллын шилдэг бүтээгдэхүүн”, “Хэрэглэгчийн анд хоршоо” гэсэн шагналын төрөлд 8 хоршоо шалгарчээ.</p> <p>3. Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодын нэгдсэн тоо, үйл ажиллагааны чиглэл, тулгарч буй бэрхшээл, нийгэм эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл, хөгжлийн өнөөгийн түвшин, ХХХААҮ-ийн салбарын хөгжил төдийгүй улс орны хөгжлийг хангах, чанар, хүртээмжийг сайжруулах, технологижуулах, мэдээлэлжүүлэх зорилгоор 2009-2010 онд СНФ Олон улсын байгууллагатай хамтран “Хоршоодын хөгжлийн суурь судалгаа”-г хийхээр харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Тендер зарлан “Хараат бус судалгааны хүрээлэн” шалгарч, судлаачдын баг 2009 оны 10 сараас хөдөө орон нутагт ажиллаж байна.</p> <p>4.Нэгдэлжих хөдөлгөөн үүсч хөгжсөний 50 жилийн ойд зориулсан “Онол практикийн бага хурал”-ыг ХААХҮХ-той хамтран зохион байгуулж, 50 гаруй хоршоологчдыг хамруулжээ.</p> <p>5.”Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодын туршлага солилцох” өдөрлөгийг УБ хотод зохион байгуулж, 60 гаруй хоршоод оролцсон байна.</p> <p>6. Анхан шатны 11 хоршоог нэгтгэн 250 хүнийг ажлын байраар хангасан “Ноосон зангилаа” дундын хоршооны бие даасан үзэсгэлэнг сурталчлах, үйл ажиллагаа, тэргүүн туршлагыг түгээх зорилгоор “Боловсрол” ТВ-тэй хамтран нэвтрүүлэг хийв.</p> <p>7. 2009 оны 5 сард МХҮНХолбооны тэргүүнээр ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан “Хоршооны тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах, хуулийн үзэл баримтлал, өөрчлөлтүүдийг тусгасан хуулийн төслийг боловсруулан УИХ-ын тамгын газарт хүргүүлж, хаврын чуулганы 6 дугаар асуудалд хэлэлцүүлэхээр тогтсон.</p> <p>8.”Бараа түүхийн эдийн биржийн тухай” хуулийн төсөлд малын гаралтай түүхий эд бэлтгэлийг нийлүүлэх анхан шатны нэгжийг(сумдад) хоршоодын зохион байгуулалтад тулгуурлан</p>
--	---

		<p>явуулах ажлыг тусгуулсан.</p> <p>9.Жижиг, дунд үйлдвэрийн хөнгөлөлттэй зээлд Хоршооны чиглэлээр 64 төсөлд 625,1 сая.төг-ийн зээл олгогдсон.</p> <p>10. TV5 телевизийн “Монгол улсаа хөгжүүлье” нэвтрүүлэгт Хоршооны талаар төрөөс баримталж буй бодлогын хүрээнд ярилцлага хийсэн.</p>
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Хөтөлбөр төсвийн тодотголын дараа (2009,06,15) батлагдсан тул 2009 онд хэрэгжүүлэх арга хэмжээний хөрөнгө төсөвт суугдаагүй байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах ажилд хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөл одоог хүртэл хуралдаагүй, үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүй иржээ. Шалтгааныг авч үзвэл: Үндэсний зөвлөлийн хуралдаан цаг үеийн байдал, зуд болон улс оронд тогтоосон өндөржүүлсэн бэлэн байдалтай холбоотойгоор хэд хэдэн удаа хойшлогдсон.</p> <p>Гэвч санхүүжилтгүй боловч зохион байгуулалтын нилээд арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.</p> <p>Иймд “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”-г 70% буюу “Шаардлага хангаж байна” гэсэн үнэлгээг өгч байна.</p>
	Хөтөлбөр хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх үнэлгээ	<p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талууд боллоцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан байна. Үндэсний зөвлөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүргээ илүү сайн явуулах шаардлагатай байна.</p>
9	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар өгөх зөвлөмж	<p>1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай санхүүжилтыг төсөвт суулгаж, батлуулах.</p> <p>2.Загвар хоршооны стандартыг боловсруулж, батлуулах</p> <p>3.Ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болон орон нутгийн бусад хоршоодтой хамтран “Дундын хоршоо” байгуулж ажиллахыг идэвхжүүлэх.</p> <p>4. Хоршооны бүтээгдэхүүн борлуулах сүлжээг бий болгох.</p> <p>5.Хөтөлбөр хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулж ажиллах шаардлагатай байна.</p>

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА